



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2016-2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН
 (2020 оны эхний хагас жилийн байдлаар тайлагнав)

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар

2020-06-30

Улаанбаатар хот

ЗГУАХ-т тусгагдсан зорилт (зорилтын дугаар)	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ (арга хэмжээний дугаар)	Хэрэгжих хугацаа	Үндсэн хэрэгжүүлэх байгууллага	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг)	2020 оны зорилтот түвшин, үр дүн (хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр)	
					Зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Хүрсэн түвшин, үр дүн, хэрэгжилтийн хувь
1	2	3	4	5	6	7
НЭГ. ЭДИЙН ЗАСГИЙН ХҮНДРЭЛИЙГ ДАВАН ТУУЛАХ ОНЦГОЙ БОДЛОГО						
Тэргүүлэх зорилт № 1. Эдийн засагт үүссэн хүндрэлийг богино хугацаанд даван туулиж, макро эдийн засгийн тэнцвэрийг хангах, эдийн засгийн бүтцийг төрөлжүүлж, түүхий эдийн үнээс хэт хамааралтай байдлыг бууруулж, төлбөрийн тэнцлийн эрсдэлийг багасгах, дунд хугацаанд учирч байгаа өрийн дарамтыг бууруулах, эдийн засгийг дархлаатай болгох, улмаар эдийн засаг дунд хугацаанд тогтвортой тэлэх бодлогыг баримтална.						

1.4. Төсвийн сахилга батыг сайжруулж, үр ашиггүй зардлыг танах, хэмнэлтийн горимд шилжүүлэх замаар төсвийн алдагдлыг бууруулна.	5.Төрийн болон орон нутгийн өмчийн улсын үзлэг, тооллогын дүнгийн мөрөөр авах арга хэмжээг хэрэгжүүлж ажиллах	2016-2020	ТӨБЗГ	0, Хөрөнгө зарцуулаагүй.	Улсын ээлжит үзлэг тооллого зохион байгуулах бэлтгэл хангагдах, Улсын төсвийн эх үүсвэр: 250.0 сая төгрөг	ТӨБХ Төрийн болон орон нутгийн өмчийн улсын үзлэг, тооллогод ашиглах төрийн өмчийн бүртгэлийн болон захиргааны статистикийн маягтуудыг шинэчлэн боловсруулж, батлах асуудлаар зөвшөөрөл авахаар Үндэсний статистикийн газарт холбогдох хууль журмын дагуу хүргүүлсэн. Үүний үр дүнд Үндэсний статистикийн газрын даргын 2020 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн А/33 дугаар тушаалаар маягтуудыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт батлан мөрдүүлэх зөвшөөрөл авсан. Мөн Сангийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2020 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн А/70 дугаар тушаалаар өмнө мөрдөж байсан маягтуудыг хүчингүй болгох асуудлыг шийдвэрлүүлэв. ТӨБЗГ-ын хуралдаанаар шинэчлэн боловсруулсан маягтуудыг батлуулахаар бэлтгээд байна. Ковид-19 цар тахлын эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор улсын үзлэг, тооллогын ажлыг хойшшуулах санал бүхий Засгийн газрын тогтоолын төслийг танилцуулгын хамт бэлтгэн ТӨБЗГ-ын 2020 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн А-1/983 дугаартай албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн. Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр хүлээгдэж
---	---	-----------	-------	-----------------------------	--	--

						байна. Засгийн газрын шийдвэрээр үзлэг, тооллогын ажлын хугацааг хойшлуулах эсэх асуудал тодорхой болно.
						<u>Өөрийн үнэлгээ: “Тодорхой үр дүнд хүрсэн” – 70 %</u>
						Тэмдэглэл: Зорилт, арга хэмжээ нь 2020 оны эхний хагас жилд шалгuur үзүүлэлт, зорилтот түвшинд бүрэн хүрээгүй ч тодорхой үр дүн гарсан гэж үзэх боломжтой. Өөреөр хэлбэл, улсын үзлэгийн бэлтгэл ажлыг хангах тодорхой арга хэмжээт хэрэгжүүлсэн.
6.Төрийн өмчийн эд хөрөнгийн эзэмшилт, ашиглалт, хадгалалт, хамгаалалт, захиран зарцуулалт, санхүү, эдийн засгийн байдалд баримтын шалгалт хийж, төлбөр зөрчлийг барагдуулж, төсвийн сахилга, хариуцлагыг дээшилүүлэх	2016-2020	ТӨБЗГ	0, Тусгайлан төсөв зарцуулаагүй.	39 байгууллагад шалгалт хийх, хуулийн хэрэгжилтийг хангах Улсын төсвийн эх үүсвэр: 37.0 сая төгрөг	ТӨХШХ Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас 2020 онд төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой 35 хуулийн этгээдийн эд хөрөнгийн эзэмшилт, ашиглалт, захиран зарцуулалт болон санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх төлөвлөгөөг баталсан. Засгийн газрын 2019 оны 438 дугаар тогтоолоор ТӨБЗГ-ын чиг үүрэг өөрчлөгдсөн, Засгийн газрын 2020 оны “Бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан эдийн засгийг дэмжих чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай” 114 дүгээр тогтоол гарсантай холбоотойгоор Сангийн яамнаас дотоод томилолтын зардлыг эхний хагас жилд хуваарилахгүйгээр зогсоосон. Үүнтэй холбоотойгоор хяналт шалгалтын төлөвлөгөөнд тусгагдсан орон нутагт байршилтай хуулийн этгээдэд хийх шалгалтыг хэрэгжүүлэх боломжгүй болсон тул нийслэл дэх 19 хуулийн этгээдийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийхээр тогтсон болно. 1. 2020 оны эхний хагас жилд дор дурдсан төлөвлөгөөт хяналт шалгалт хийж гүйцэтгэлээ. Үүнд: Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргын 2020 оны 1-7 дугаар тушаалаар баталсан ажлын хэсгийн бүрэлдэхүүн, удирдамжийн дагуу “Монгол-Ус” ТӨҮГ, “Аялал жуулчлалын хөгжлийн төв” ТӨҮГ, “Техник спортын төв” ТӨҮГ, “Монгол Кувейтын байгаль хамгаалах төв” ТӨҮГ, “Цагаан шонхор” ТӨҮГ, “Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ, “Мэдээлэл холбооны сүлжээ” ХХК зэрэг 7 хуулийн этгээдэд тус тус хяналт шалгалт хийсэн. Төлөвлөгөөт хяналт шалгалтаар нийт 16.8 тэрбум төгрөгийн зөрчил, дутагдал илрүүлж, 5 байгууллагад хийсэн шалгалтын дүн, тайланг ТӨБЗГ-ын хуралдаанд танилцуулан, “Шалгалтын мөрөөр авах арга хэмжээний тухай” тогтоолыг гаргуулж, хэрэгжилтийг хангуулахаар ажиллаж байна. Энэ хүрээнд шалгалтад хамрагдсан хуулийн этгээдийн удирдлагад зөрчил, дутагдлыг арилгах хугацаатай үүрэг даалгавар, зөвлөмжийг шалгалтын	

						<p>тайлангийн хамт хүргүүлсэн.</p> <p>“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ, “Монголросцветмет” ТӨҮГ-ын 2016-2019 оны үйл ажиллагаанд санхүүгийн иж бүрэн хяналт шалгалт, “МИАТ” ТӨХК-ийн 2018, 2019 оны үйлдвэрлэл, удирдлага, санхүү, аж ахуйн үйл ажиллагаанд шалгалт хийж, санал дүгнэлт гаргах Засгийн газраас байгуулсан ажлын хэсгийн бүрэлдэхүүнд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хяналт шалгалтын мэргэжилтнүүд ажиллаж, дүгнэлт, тайланг бичиж ажлын хэсэгт хүргүүлсэн.</p> <p>2. Тайлант хугацаанд төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг “ТОСК” ХХК, “Геологийн төв лаборатори” ТӨҮГ-т хийж, ЗГХЭГ-ын 2019 оны ХЭГ/3522, 2020 оны ХЭГ/296 тоот албан бичигт дурдсан мэдээллийг тус тус няялан шалгаж, санал дүгнэлт, тайланг хүргүүлсэн. Мөн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргын 2020 оны А/30 дугаар тушаалаар ажлын хэсэг байгуулан байгууллагын дотоод хяналт, санхүүгийн сахилга батыг сайжруулах зорилгоор ТӨБЗГ-ын 2016 оноос хойшхи санхүүгийн баримтыг шалгаж, санал, дүгнэлт гаргаж, Даргын зөвлөлөөр хэлэлцэхээр бэлтгээд байна.</p> <p>Өөрийн үнэлгээ: “Үр дүнтэй” – 100 %</p> <p>Тэмдэглэл: Зорилт, арга хэмжээ нь 2020 оны эхний хагас жилийн шалгуур үзүүлэлт, зорилтот түвшинд хүрсэн гэж үзэх боломжтой.</p>
	7.Төсөвт байгууллагын эд хөрөнгийн эзэмшилт, ашиглалтын байдалд зорилтот болон хэсэгчилсэн мониторинг хийж, зөрчил дутагдлыг арилгуулах арга хэмжээ авах	2017-2020	ТӨБЗГ	0, Хөрөнгө зарцуулаа гүй.	<p>10 байгууллагыг хамруулах, өмчид тавих хяналт сайжирч, төсвийн хэмнэлт бий болох</p> <p>Улсын төсвийн эх үүсвэр: 10.0 сая төгрөг</p>	<p>ТӨХШХ</p> <p>Коронавируст халдварын цар тахлын улмаас хяналт шалгалтын төлөвлөгөөнд тусгагдсан эрүүл мэндийн салбарын 10 төсөвт байгууллагын эд хөрөнгийн эзэмшилт, ашиглалтын байдалд хийх шалгалт хойшлогдож, оны суулийн хагас жилд хийхээр төлөвлөөд байна.</p> <p>Өөрийн үнэлгээ: “Үнэлэх боломжгүй”</p> <p>Тэмдэглэл: Монгол Улсын Засгийн газар, Улсын онцгой комиссын шийдвэрээр коронавируст халдварын цар тахлаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч, улсын хэмжээнд хорио цээрийн дэглэм тогтоосон нөхцөл байдлын улмаас ТӨБЗГ-аас хяналт шалгалтын ажлыг хойшлуулсан.</p>

ХОЁР. ЭДИЙН ЗАСГИЙН ТОГТВОРТОЙ ӨСӨЛТИЙГ ХАНГАХ БОДЛОГО

Тэргүүлэх зорилт № 2.2. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын тогтвортой хөгжлийг хангах зорилгоор “ЭРҮҮЛ ХҮНС-ЭРҮҮЛ МОНГОЛ ХҮН” үндэсний хөтөлбөр, “ҮЙЛДВЭРЖИЛТИЙН 21:100” хөтөлбөр, “ҮНДЭСНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛ” хөтөлбөр, “MAX, СҮҮНИЙ АНХДУГААР АЯН”-ыг шинээр эхлүүлж, “АТРЫН-III АЯН”-ыг ургэлжүүлэн хэрэгжүүлнэ.

2.58. Хөдөө аж ахуйн биржээр арилжаалах бараа, түүхий эдийн нэр төрөл, тоо хэмжээг нэмэгдүүлж, үйл ажиллагааг боловсронгуй болгоно.	1.Хөдөө аж ахуй болон үйлдвэрлэл, үйлчилгээний хоршоодын бэлтгэсэн малын гаралтай түүхий эдийг хөдөө аж ахуйн биржээр арилжих ажлыг эрчимжүүлэх	2017-2020	ХХААХҮЯ (ТӨБЗГ хамтран хэрэгжүүлэгч)		10 хоршоог биржийн арилжаанд оролцуулах Улсын тэсвийн эх үүсвэр: 200.0 сая төгрөг	ТӨУЗХ Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 2 дугаар сарын 04-ний өдрийн 47 дугаар тогтооолоор “Хөдөө аж ахуйн бирж” ХХК-ийн төрийн эзэмшилийн хувьцааг эзэмшигчийн эрхийг хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хэрэгжүүлж байхаар тогтоосон тул Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт уг зорилт, арга хэмжээний 2020 оны зорилтот түвшин хамаarahгүй болсон. Өөрийн үнэлгээ: “Үнэлэх боломжгүй” Тэмдэглэл: 2019 оны зорилтот түвшин 100 хувь хэрэгжиж, “Үр дүнтэй” үнэлгээтэй дүгнэгдсэн. 2020 оны зорилтот түвшингийн хэрэгжилт ТӨБЗГ-т хамаarahгүй болсонтой холбоотой гүйцэтгэлийг үнэлэх боломжгүй.
---	---	-----------	---	--	--	--

Тэргүүлэх зорилт № 2.3. Геологи, уул уурхайн салбарын хөрөнгө оруулалтын таатай орчинг бүрдүүлэх, уул уурхайн салбарын тогтвортой хөгжлийг хангах, олон улсын эрдсийн зах зээл дэх Монгол Улсын өрсөлдөх чадварыг дээшлүүлнэ.

2.70. Газрын тосны олборлолтыг тогтвортой нэмэгдүүлэн, газрын тос боловсруулах үйлдвэр байгуулна.	1.Газрын тос боловсруулах үйлдвэр барих төслийн нэгж байгуулах, үйлдвэрийн дэд нарийвчилсан судалгаа, үйлдвэр болон дамжуулах хоолойн газрын асуудлыг шийдвэрлэх	2016-2017	УУХҮЯ (ТӨБЗГ хамтран хэрэгжүүлэгч)	-	-	ТӨУЗХ Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 323 дугаар тогтооолоор “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ТӨХХК-ийн төрийн өмчийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчээр Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам байхаар тогтоосон тул Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт уг зорилт, арга хэмжээний 2020 оны зорилтот түвшин хамаarahгүй болсон. Өөрийн үнэлгээ: “Үнэлэх боломжгүй” Тэмдэглэл: 2019 оны зорилтот түвшингийн хувьд зорилт, арга хэмжээ нь шалгuur үзүүлэлт, зорилтот түвшиндээ хүрч, үр дун гарсан тул 100 хувь буюу “Үр дүнтэй” үнэлгээтэй дүгнэгдсэн. 2020 оны зорилтот түвшингийн хэрэгжилт ТӨБЗГ-т хамаarahгүй болсон тул гүйцэтгэлийг үнэлэх боломжгүй.
---	--	-----------	---------------------------------------	---	---	---

	2.Төслийн санхүүжилт, хөрөнгө оруулалт, хувь эзэмшилийн хэмжээний талаар санал боловсруулах, холбогдох шийдвэрийг гаргуулах,	2017	УУХҮЯ (ТӨБЗГ хамтран хэрэгжүүлэгч)	-	-	ТӨУЗХ Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 323 дугаар тогтооолоор “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ТӨХХК-ийн төрийн өмчийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчээр Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам байхаар тогтоосон тул Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт уг
--	--	------	---------------------------------------	---	---	--

	төсөл хэрэгжүүлэх хуулийн этгээдийг сонгон шалгаруулах бэлтгэлийг хангах					зорилт, арга хэмжээний 2020 оны зорилтот түвшин хамаарахгүй болсон. <u>Өөрийн үнэлгээ:</u> “Үнэлэх боломжгүй” Тэмдэглэл: 2018, 2019 оны зорилтот түвшингийн хувьд зорилт, арга хэмжээ нь шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ хүрч, үр дун гарсан тул 100 хувь буюу “Үр дүнтэй” үнэлгээтэй дүгнэгдсэн. 2020 оны зорилтот түвшингийн хэрэгжилт ТӨБЗГ-т хамаарахгүй болсон тул гүйцэтгэлийг үнэлэх боломжгүй.
Тэргүүлэх зорилт № 2.5. Улс орны эдийн засгийн аюулгүй байдлын үндэс болсон эрчим хүчиний тогтвортой, найдвартай ажиллагааг бүрэн хангаж, экспортын чадамжтай болох нөхцлийг бүрдүүлиэ.						
2.97. Улс орны эдийн засгийн аюулгүй байдал, тогтвортой хөгжлийн үндэс болсон суурь салбарын тасралтгүй, найдвартай ажиллагааг хангах зорилгоор ашиглалтад байгаа цахилгаан станцуудын хүчин чадлыг өргөтгэх, шинэчлэх ажлыг хэрэгжүүлнэ. /Чойбалсангийн ДЦС, Улаанбаатарын Гуравдугаар ДЦС/	1.Дарханы ДЦС-ыг 35 МВт-аар өргөтгэх	2016-2018	ЭХЯ (ТӨБЗГ хамтран хэрэгжүүлэгч)	-	-	ТӨУЗХ Төслийн ажлыг хүлээлгэн өгөх техникийн комисс, Улсын комисс ажилласан. Дарханы ДЦС-ыг 35 МВт-аар өргөтгэх теслийн ажил бүрэн дуусч, 2019 онд ашиглалтад хүлээн авсан. <u>Өөрийн үнэлгээ:</u> “Үр дүнтэй” – 100% Тэмдэглэл: Зорилт, арга хэмжээ нь шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ бүрэн хүрсэн. Улсын комисст хүлээлгэн өгсөн.
	2.Эрдэнэтийн ДЦС-ыг 35 МВт-аар өргөтгэх	2017-2018	ЭХЯ (ТӨБЗГ хамтран хэрэгжүүлэгч)	-	-	ТӨУЗХ Барилга угралтын ажил 75.0 хувьтай явагдаж байгаа бөгөөд Ковид-19 цар тахлын улмаас ажиллах хүч хятадын талаас орж ирэх боломжгүйгээс хүлээгдэж байна. 2020 оны 09 дүгээр сард хүлээлгэж өгөх төлөвлөгөөтэй ажиллах байна. <u>Өөрийн үнэлгээ:</u> “Тодорхой үр дүнд хүрсэн” – 70% Тэмдэглэл: Зорилт, арга хэмжээний хугацааны зорилтот түвшин хоцорч байгаа. Зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх ажил үргэлжилж байна. ТӨБЗГ-т шууд хамаарахгүй.
	3.Чойбалсангийн ДЦС-ыг 50 МВт-аар өргөтгэх	2018-2020	ЭХЯ (ТӨБЗГ хамтран хэрэгжүүлэгч)	Барилга угсралтын ажлын гүйцэтгэл 80 хувиас доошгүй байх		ТӨУЗХ Эрчим хүчиний ямны Төрийн нарийн бичгийн даргын 2018 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 345 тоот тушаалаар байгуулагдсан үнэлгээний хороо нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу “Чойбалсангийн ДЦС-ын 50 МВт-р өргөтгэх” нээлттэй тендер шалгаруулалтыг зохион байгуулсан. Үнэлгээний хорооны 2019 оны 06 дугаар сарын 14-ны өдрийн дүгнэлтээр ТВЕА co.ltd компани хамгийн сайн үнэлгэдсэн тендерээр шалгарсан.

					Гадаад зээлийн эх үүсвэр: 34,000.0 сая төгрөг	Төслийн нэгжийг байгуулан ажиллуулж байна. Станцын өргөтгөл, шинэчлэлийн ажлыг графикийн дагуу эхлүүлсэн байна. Барилга угсралтын ажил эхлээд 10 орчим хувьтай байна. Үндсэн тоног төхөөрөмжийн захиалга хийгдсэн, зураг төсөв бэлэн болсон. <u>Өөрийн үнэлгээ:</u> “Эрчимжүүлэх шаардлагатай” – 40%
4.Гуравдугаар ДЦС-ыг 250 МВт-аар өргөтгөх	2018-2020	ЭХЯ (ТӨБЗГ хамтран хэрэгжүүлэгч)		Ашиглалтад орох Гадаад зээлийн эх үүсвэр: 300,000.0 сая төгрөг	ТӨУЗХ Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 02 дугаар сарын 12-ны өдрийн хуралдаанд төслийн асуудлыг Эрчим хүчний яамнаас танилцуулсан. “Улаанбаатарын дулааны гуравдугаар цахилгаан станцын сууринлагдсан хүчин чадлыг 250 МВт-аар нэмэгдүүлэх төслийн талаарх танилцуулгыг Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлж, төслийг хэрэгжүүлэх эсэх асуудлаар удирдамж чиглэл...авах”-аар Эрчим хүчний сайдын 2020 оны 04 дугаар сарын 07-ны өдрийн А/1145 дугаартай албан бичгийг УАБЗ-ийн Нарийн бичгийн даргад хүргүүлж, шаардлагатай нэмэлт мэдээллээр ханган ажиллаж байгаа мэдээлэлтэй байна. <u>Өөрийн үнэлгээ:</u> “Үнэлэх боломжгүй”	ТЭМДЭГЛЭЛ: Зорилт, арга хэмжээ нь шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ хүрээгүй, хугацааны зорилтот түвшин хоцорч байгаа. Зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх ажлыг эхлүүлсэн байна. ТӨБЗГ-ын үйл ажиллагаанаас хэрэгжилт нь шууд хамаarahгүй байна.

ГУРАВ. НИЙГМИЙН БОДЛОГО

Тэргүүлэх зорилт № 3.1. Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлогыг боловсруулж, хүн амыг аливаа өвчинеөс урьдчилан сэргийлэх, оношлох, эмчилгээ үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх эдийн засгийн тооцооллыг бий болгож, хүний нөөцийн чадавхыг бэхжүүлнэ. Хүн амыг өвчинеөс урьдчилан сэргийлэх мэдлэг, дадал, хандлагад төлөвшүүлж нийгмийн эрүүл мэндэд чиглэсэн тусламж үйлчилгээг эрс сайжруулах, Халдварт бус өвчинеөс сэргийлэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний бодлого төлөвлөлтөд урт болон дунд хугацааны хөтөлбөр боловсруулж, чанар хүртээмжийг дээшлүүлнэ. Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн хөгжлийг хангаж, нийгмийн хамгааллыг сайжруулна. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанартай уялдсан эрүүл мэндийн санхүүжилтийн тогтолцоог боловсронгуй болгоно.

3.1.4. Эрүүл мэндийн салбарын санхүүжилтийг үе шатгайгаар 2	10.Эрүүл мэндийн салбарын дэд бүтэц, тоног төхөөрөмжийн байдалд үнэлгээ хийж, хөрөнгө төлөвлөлтийн тогтолцоог бүрдүүлэх	2017-2020	ЭМЯ (ТӨБЗГ хамтран хэрэгжүүлэгч)	-	Төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах, Улсын төсвийн эх	ТӨБХ Эрүүл мэндийн яамны шууд хамаарах зорилт, арга хэмжээ. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт хамааралгүй заалт. <u>Өөрийн үнэлгээ:</u> “Үнэлэх боломжгүй”
---	---	-----------	-------------------------------------	---	--	--

дахин нэмэгдүүлнэ.					үүсвэр: 3,000.0 сая төгрөг	Тэмдэглэл: ТӨБЗГ-т хамаарахгүй байна. 2017 оны жилийн эцсийн тайланг ТӨБЗГ-ын Даргын Зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэхэд “Үнэлэх боломжгүй” тул цаашид хяналтаас хасуулах санал, шийдвэр гарсан. Мөн 2018 оны жилийн эцсийн тайланг Даргын Зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэх үеэр энэ зорилт, арга хэмжээг ТӨБЗГ-т “Үнэлэх боломжгүй” гэж дүгнэж байгаа болон ингэж дүгнэх боломжтой эсэх талаар ЗГХЭГ-ын ХШУДАГ-т чиглэл хүсэх, ТӨБЗГ-т хамаарахгүй байгаа тухай тайлбар хүргүүлэхээр шийдвэрлэсэн. Үүний дагуу ТӨБЗГ-ын 2019 оны 01 дугээр сарын 22-ны өдрийн А-1/154 дугаартай “Чиглэл хүсэх тухай” албан бичгийг ЗГХЭГ-ын ХШУДАГ-т хүргүүлсэн болно.
Тэргүүлэх зорилт № 3.2.2. Шинжлэх ухааны удирдлага, зохион байгуулалтын тогтолцоог олон улсын хөгжлийн чиг хандлагад нийцүүлэн боловсронгуй болгож, үр дүнд суурилсан санхүүжилтийн системийг нэвтрүүлж, мэдлэгт суурилсан инноваци, технологи, үйлдвэрлэлийг хөгжүүлж, шинжлэх ухааны үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнийг нэмэгдүүлнэ.						
3.2.33. Шинжлэх ухаан, технологи, инновацийн салбарт олон улсын жишигт нийцсэн барилга, байгууламж, лабораторын орчин нехцел бүхий дэд бүтцийг бий болгохыг дэмжинэ.	10.Уул уурхай, шинжлэх ухааны чиглэлд бүх нийтийн боловсролыг дээшлүүлэх хүрээнд Шинжлэх ухаан, танин мэдэхүйн мэдээллийн төв байгуулах барилга, байгууламжийн асуудлыг шийдвэрлэх	2018	ЦЭКАА (ТӨБЗГ хамтран хэрэгжүү- лэгч)	Тогтмол үйл ажиллагаа- тай болох, Улсын төсвийн эх үүсвэр: 50.0 сая төгрөг	ТӨБХ Шинжлэх ухаан, технологи, инновацийн салбарт олон улсын жишигт нийцсэн барилга, байгууламж, лабораторын орчин нехцел бүхий дэд бүтцийг бий болгох, уул уурхай, шинжлэх ухааны чиглэлд бүх нийтийн боловсролыг дээшлүүлэх хүрээнд Шинжлэх ухаан, танин мэдэхүйн мэдээллийн төв байгуулах барилга, байгууламжтай холбоотой асуудлаар Цөмийн энергийн комиссын Ажлын алба, бусад холбогдох байгууллагаас Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт хандаагүй болно. Нэмэлт мэдээлэл: Холбогдох байгууллагаас 2018 онд 200.0 сая төгрөгийн төсвийн санал өгсөн боловч 2019 оны улсын төсөв, хөрөнгө оруулалтын төсөв, төсөл, арга хэмжээний жагсаалтад тусгагдаагүй байна. Тус төвийн барилга байгууламжийн асуудал шийдвэгдэх найдвар бага тул танин мэдэхүй, сургалтын зориулалтаар өргөн ашиглаж байгаа Virtual Reality (VR) хэмээх технологийг ашиглах боломжийг хэрэглэхээр төлөвлөж, түүнд шаардлагатай техник хэрэгслийн зардлыг 2020 оны улсын төсөвт тусгтуулах, тус төвийг байгуулан ажиллахаар Цөмийн энергийн комиссын Ажлын албанаас өгсөн боловч 2020 оны төсөвт зохих төсөв тусгагдаагүй мэдээлэлтэй байна. Өөрийн үнэлгээ: “Үнэлэх боломжгүй” Тэмдэглэл: ТӨБЗГ-т одоогоор шууд хамаарахгүй байна. Уг төвийг байгуулах санхүүгийн эх үүсвэр, барилга байгууламжийн асуудал эцэслэн шийдвэрлэгдсэний дараа төрийн өмчид бүртгэх, холбогдох байгууллагаас ТӨБЗГ-т хандах үед ТӨБЗГ-ын чиг үүргийн ажил хийгдэж, тодорхой мэдээлэл бий болох боломжтой гэж үзэв.	2018 оны жилийн эцсийн тайланг Даргын Зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэх

						үеэр энэ зорилт, арга хэмжээг ТӨБЗГ-т “Үнэлэх боломжгүй” гэж дүгнэж байгаа болон ингэж дүгнэх боломжтой эсэх талаар ЗГХЭГ-ын ХШУДАГ-т чиглэл хүсэх, ТӨБЗГ-т хамаarahгүй байгаа тухай тайлбар хүргүүлэхээр шийдвэрлэсэн. Үүний дагуу ТӨБЗГ-ын 2019 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн А-1/154 дугаартай “Чиглэл хүсэх тухай” албан бичгийг ЗГХЭГ-т хүргүүлсэн болно.
--	--	--	--	--	--	---

ТАВ. ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО

Тэргүүлэх зорилт № 5.2. Эдийн засаг, бизнесийн эрх зүйн орчны тогтвортой байдлыг чухалчилж, шаардлагатай өөрчлөлт хийхдээ эрх ашиг нь хөндөгдөх этгээдээс заавал асууж, саналыг нь авах соёлыг хэвшигүүлэх зарчмыг баримтална.

ТӨҮЗХ
<p>5.2.1. Терийн болон орон нутгийн өмчийн ашиглалт, төрийн болон орон нутгийн өмчит компаниудын ашигт ажиллагаа, засаглал, өмч хувьчлалын бодлогыг сайжруулж, төр, хувийн хэвшлийн түншлэлийг шинэ шатанд гарана.</p> <p>1. Алдагдалтай ажиллаж байгаа төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаа, эдийн засгийн байдалд судалгаа, дүн шинжилгээ хийж, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлон, хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах</p> <p>2016-2020</p> <p>ТӨБЗГ</p> <p>-</p> <p>Төлөвлөгөөний хэрэгжилт бүрэн хангагдах, 15.0 тэрбум төгрөгийн ногдол ашгийн орлого төвлөрүүлж эдийн засгийн төлөвлөсөн үр ашиг нэмэгдэх</p> <p>ТӨБЗГ-аас төлөөлөл хэрэгжүүлэн ажиллаж байгаа төрийн өмчит 21 үйлдвэрийн газар, төрийн өмчит 46 хувьцаат компани, төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай 4 компани, төрийн өмчийн оролцоотой 2 компани, нийт төрийн өмчит 73 хуулийн этгээдийн 2019 оны жилийн эцсийн санхүү, эдийн засгийн үндсэн үзүүлэлтийг урьдчилсан байдлаар нэгтгэн гаргаж, таницуулга, мэдээллийг бэлтгээд байна.</p> <p>Төрийн өмчит болон төрийн оролцоотой өдгээр 73 хуулийн этгээд нь 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн дун (2020 оны 1 дүгээр улиралд аудитаар баталгаажсан)-ээр 24 их наяд 664 тэрбум төгрөгийн хөрөнгө эзэмшиж, 26480 гаруй ажиллагадтайгаар үйл ажиллагаа явуулан 9 их наяд 992 тэрбум төгрөгийн орлого олж, 1,664.6 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажилласан байна.</p> <p>Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн аудитаар баталгаажсан 2019 оны санхүүгийн тайланд тусгагдсан цэвэр ашгийн дунд үндэслэн терд ногдох төрийн өмчийн ногдол ашгийн төлөвлөгөө (хувь, хэмжээг тусгасан)-г боловсруулан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2020 оны 05 дугаар сарын 28-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн 315 дугаар тогтооюор батлуулсан. Уг тогтооюор төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой нийт 53 хуулийн этгээдээс нийт дунгээр 173.6 тэрбум төгрөгийн ногдол ашгийг 2020 оны төсөвт төвлөрүүлэхээр тогтоосон. Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хуульд нийцүүлэн тогтоосон төрийн өмчийн ногдол ашгийг улсын төсөвт төвлөрүүлэх ажлыг зохион байгуулалтаар хангаж, хяналт тавин ажиллаж байна.</p> <p>Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 137 дугаар тогтоол, Зам, тээврийн хөгжлийн яам болон “МИАТ” ТӨХК-ийн саналыг үндэслэн 2020 онд “МИАТ” ТӨХК-ийн 2019 оны цэвэр ашгаас төрийн өмчийн ногдол ашиг хуваарилахгүй байх асуудлыг ТӨБЗГ-ын 05 дугаар сарын 28-ны</p>

						<p>өдрийн 316 дугаар тогтоолоор шийдвэрлэсэн.</p> <p>Өөрийн үнэлгээ: “Тодорхой үр дүнд хүрсэн” – 70%</p> <p>Тэмдэглэл: Зорилт, арга хэмжээ нь шалгуур үзүүлэлт, зорилтот түвшинд хүрэх боломжтой, удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээ авч ажилласан, зарим үр дүн гарсан.</p>
	2.Төрийн болон орон нутгийн өмчийн талаар хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх, компанийн сайн засаглалыг хөгжүүлэх замаар төрийн өмчийн үр өгөөжийг нэмэгдүүлэх	2016-2020	ТӨБЗГ	-	Компанийн засаглалын зарчмууд хэрэгжих	<p>ТӨУЗХ, ХЭЗА</p> <p>Төрийн өмчит 50 компани, төрийн өмчийн оролцоотой 2 компани, төрийн өмчит 21 үйлдвэрийн газарт төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх ажлыг удирдлага менежментээр ханган ажиллав. Эдгээрээс төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой 51 компанийн 39 төлөөлөн удирдах зөвлөлд 229 албан хаагч төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэн ажилласан байна.</p> <p>Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргын 2020 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн А/26 дугаар тушаалаар ажлын хэсэг томилон ажиллуулж, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой 24 компани, төрийн өмчит 21 үйлдвэрийн газрын 2019 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний биелэлтийг дүгнэн, 45 захирлын контрактын биелэлтийг газрын хуралдаанаар хэлэлцүүлэн холбогдох арга хэмжээ авч ажиллав. Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой 45 хуулийн этгээдийн 2019 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний биелэлтийг ТӨБЗГ-ын хуралдаанаар, 27 компанийн биелэлтийг Хувьцаа эзэмшигчдийн хурлаар тус тус хэлэлцүүлж, нийт 72 захирлын контрактыг дүгнэж, 68 захирлын гэрээг сунгахаар, 3 захирлын гэрээний биелэлтийг хангалтгүй гэж шийдвэрлэсэн. 1 захирлын гэрээг тухайн төрийн өмчит компанийн төрийн эзэмшилийн хувьцааны 70 хувийг эзэмшигч Эрчим хүчний яамнаас дүгнэх боломжгүй гэж үзсэн.</p> <p>Мөн тэдгээр 72 хуулийн этгээдийн 2020 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинг ТӨБЗГ-ын хуралдаан болон Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлэн батлуулж, 2020 оны үйл ажиллагааг нь чиглүүлэн ажиллах хүрээнд 2019 оны санхүүгийн тайланд хийсэн хөндлөнгийн аудитын дүгнэлт зөвлөмжийг хэрэгжүүлэх, шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах, зөрчил дутагдлыг арилгах чиглэлээр албан даалгавар хургуулэн хэрэгжилтийг хангуулах арга хэмжээ аван ажиллаж байна.</p> <p>Тайлант хугацаанд төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн гүйцэтгэх удирдлага, Төлөөлөн удирдах зөвлөлийн</p>

						<p>гишүүд, эрх бүхий албан хаагчдыг чадавхижуулах чиглэлээр Компанийн засаглалын хөгжлийн төв, Компанийн засаглалын үндэсний төв ТББ-тай хамтран ажиллах, сургалт зохион байгуулах талаар хамтын ажиллагааг ургэлжлүүлж байна. Компанийн засаглалын ахисан шатны сургалтанд хамрагдсан 500 хүнд гэрчилгээ олгон баталгаажуулав.</p> <p>Шинээр байгуулагдсан компанийн гүйцэтгэх захирал, ТУЗ-ийн гишүүд болон төрийн өмчит үйлдвэрийн газрын захирлуудыг компанийн засаглалын сургалтанд хамруулах ажлыг зохион байгуулахаар бэлтгэж байна. Өвөрхангай аймгийн Орон нутгийн өмчит компанийн гүйцэтгэх захирал, ТУЗ-ийн гишүүдийг Компанийн засаглалын хөгжлийн төв ТББ-аас зохион байгуулсан компанийн засаглалын цахим сургалтанд хамруулав.</p> <p>Өөрийн үнэлгээ: “Тодорхой үр дүнд хүрсэн” – 70%</p> <p>Тэмдэглэл: Зорилт, арга хэмжээ нь шалгуур үзүүлэлт, зорилтот түвшинд бүрэн хүрэх боломжтой, удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээ авч ажилласан, зарим үр дүн гарсан.</p>
	3.Төрийн өмчит хуулийн этгээдийг өөрчлөн байгуулах, хувьчлах үндсэн чиглэлийг боловсруулан батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллах	2017-2020	ТӨБЗГ	-	Үндсэн чиглэлийн хэрэгжилтийг хангах	<p>ТӨУЗХ</p> <p>ТӨБЗГ-аас 2018 онд “Төрийн өмчийг 2018-2020 онд хувьчлах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулж, Ерөнхий сайд, Засгийн газарт 2018 оны 03 дугаар сарын 21-нд хүргүүлсэн. Тус төслийг тухайн үед Засгийн газрын хуралдаанаар хэлэлцээд 23 хуулийн этгээдийг бүрэн хувьчлах, 4 хуулийн этгээдийн төрийн эзэмшилийн хувь хэмжээг бууруулах, нийт 27 хуулийн этгээдийг хувьчлах саналыг Улсын Их Хуралд 2018 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн ЗГ-1/112 дугаар албан бичгээр өргөн барьсан. Улсын Их Хурлаас саналыг хэлэлцээд Эдийн засгийн байнгын хорооны дэргэд дэд ажлын хэсэг байгуулан дахин нарийвчлан судлахыг даалгасан. Монгол Улсын Засгийн Газрын 2019 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн хуралдааны 22 дугаар тэмдэглэлээр Монгол Улсын Засгийн Газрын 2018 оны 5 дугаар сарын 29-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Улсын Их Хурлын “Төрийн өмчийг 2018-2020 онд хувьчлах үндсэн чиглэл батлах тухай” тогтоолын төслийг эгүүлэн татах нь зүйтэй гэсэн шийдвэр гаргасан.</p> <p>Өөрийн үнэлгээ: “Үнэлэх боломжгүй”</p> <p>Тэмдэглэл: Зорилт, арга хэмжээ нь шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ хүрээгүй. ТӨБЗГ-ын үйл ажиллагаанаас хэрэгжилт нь шууд хамаарахгүй байна.</p>

						<p>Монгол Улсын Улсын Их Хурлын 2020 оны ээлжит сонгуулийн үр дүнд байгуулагдсан Засгийн газрын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт “Төрийн өмчийг 2021-2024 онд хувьчлах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэл”-ийг боловсруулж, хэрэгжүүлэх асуудлаар тодорхой санал тусган, холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.</p>
4. Төрийн өмчит хуулийн этгээдтэй “Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээ” байгуулж, дүгнэх, төрийн өөрийн өмчийн эд хөрөнгө, илүүдэлтэй байр талбайг түрээслүүлэн, орлогыг төсөвт төвлөрүүлэх	2016-2020	ТӨБЗГ	0	650.0 сая төгрөгийн орлого төвлөрүүлэх, Улсын төсвийн эх үүсвэр: 30.0 сая төгрөг	<p>ТӨБХ</p> <p>2019 онд нийслэл, 21 аймагт ажиллан “Төрийн өмчийн эд хөрөнгийн эзэмшилт, хадгалалт, хамгаалалтад хяналт тавих журам”-ын дагуу төрийн өмчит нийт 972 хуулийн этгээд (салбар нэгж орсон дүнгээр)-тэй “Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээ”-ний биелэлтийг дүгнэх, гэрээг шинэчлэн байгуулах ажлыг хийж гүйцэтгэсэн. Энэ ажлын дүнгээр илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай тайлан, дүгнэлтийг ТӨБЗГ-ын хуралдаанаар хэлэлцэн 2019 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн “Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээний биелэлтийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай” 611 дүгээр тогтоолыг баталсан. Энэхүү тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор төрийн өмчит хуулийн этгээдэд илэрсэн зөрчил дутагдлыг арилгах талаар зөвлөмж боловсруулан 2020 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн А-1/457 дугаар албан бичгээр хургуулж, хэрэгжилтийг хангуулах арга хэмжээ аван ажиллаж байна.</p> <p>ТӨБЗГ-ын 2019 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 26 дугаар тэмдэглэлээр ТӨБЗГ-ын 2019 оны 400 дугаартай тогтоолоор батлагдсан “Төрийн өмчийн эд хөрөнгийн эзэмшилт, хадгалалт, хамгаалалтад хяналт тавих журам”-д өөрчлөлт оруулах нь зүйтэй гэж үзсэний дагуу холбогдох журам, зааварт өөрчлөлт оруулахаар төслийг боловсруулж байна.</p> <p>Төрийн өмчит нийт 87 хуулийн этгээдийн эзэмшилд байгаа төрийн өөрийн өмчийн хөрөнгө, байр талбайг түрээслүүлсэн асуудалтай холбоотой 696 түрээсийн гэрээг иргэн, хуулийн этгээдтэй байгуулах ажлыг зохион байгуулж, 2.0 тэрбум төгрөгийн түрээсийн орлогыг улсын төсөвт төвлөрүүлэхээр хяналт тавин ажиллаж байна. 2020 оны 06 дугаар сарын 25-ны байдлаар нийт 387,630,687.58 төгрөгийн түрээсийн орлогыг улсын төсөвт төвлөрүүлээд байна.</p> <p>Өөрийн үнэлгээ: “Үр дунтэй” – 100 %</p> <p>Тэмдэглэл: Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хуулийн 3 дугаар зүйлд баталсны дагуу төрийн өөрийн өмчийн байр, талбай түрээслүүлсний орлого 1.2 тэрбум төгрөгийг 2020 оны улсын төсөвт төвлөрүүлэх төлөвлөгөөтэй бөгөөд зорилт, арга хэмжээ нь шалгуур</p>	

						үзүүлэлт, зорилтот түвшинд бүрэн хүрэх боломжтой тооцоо гарч байгаа болно.
	5.Төсөвт байгууллагуудын саналыг үндэслэн элэгдлээрээ анхны өргөө нөхсөн, ашиглалтгүй автомашиныг нээлтгэй дуудлагын худалдаагаар худалдаж, орлого төвлөрүүлэх арга хэмжээ авах	2016-2020	ТӨБЗГ	0	100.0 сая төгрөгийн орлого төвлөрүүлэх, Улсын төсвийн эх үүсвэр: 5.0 сая төгрөг	<p>ТӨБХ</p> <p>Төрийн өмчит хуулийн этгээдийн саналыг үндэслэн төрийн өмчийн эд хөрөнгийг худалдаах асуудлыг тухай бүр ТӨБЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлж, тогтоолоор шийдвэрлүүлж байна. 2020 оны 6 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар дуудлага худалдаанаас нийт 88.4 сая төгрөгийн орлогыг улсын төсөвт төвлөрүүлсэн дүнтэй байна.</p> <p>Өөрийн үнэлгээ: “Үр дүнтэй” - 100%</p> <p>Тэмдэглэл: ЗГУАХХАХТ-нд батлагдсан 2020 оны зорилтот түвшинээр улсын төсөвт 100.0 сая төгрөгийн орлого төвлөрүүлэх төлөвлөгөөтэй бөгөөд эхний хагас жилийн тайлангийн дүнгээс дүгиэхэд зорилт, арга хэмжээ нь шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ бүрэн хүрэх боломжтой байна.</p>
	6.Төрийн өмчит хуулийн этгээдийн эзэмшилд байгаа эд хөрөнгийг илүүдэлтэй байгууллагаас дутагдалтай байгууллагад шилжүүлэх замаар хэрэгцээ шаардлагыг хангах зохицуулалт хийх, шаардлага хангахгүй хөрөнгийг акталж устгах, шинээр хөрөнгө худалдан авах асуудлыг оновчтой шийдвэрлэж, зардал хэмнэх, үр ашгийг дээшлүүлэх бодлого хэрэгжүүлэх	2016-2020	ТӨБЗГ	-	Төсвийн зардал буурах	<p>ТӨБХ</p> <p>2020 оны эхний хагас жилд төрийн өмчит хуулийн этгээдээс ирүүлсэн санал, хүсэлтийг судлан боловсруулж, нийт дунгээр, ТӨБЗГ-ын хуралдааны 184 тогтоол, газрын даргын 160 албан бичгээр 794 (давхардсан тоогоор) хуулийн этгээдийн 60715 нэрийн 1,637.2 тэрбум төгрөгийн хөрөнгийн хөдлөл, өөрчлөлтэй холбоотой асуудлыг шийдвэрлүүлсэн байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - 405 байгууллагын 21607 нэрийн 286.0 тэрбум төгрөгийн элэгдэж дууссан, ашиглалтын шаардлага хангахгүй болсон хөрөнгийг акталж, данснаас хасах; - 145 байгууллагын 2739 нэр төрлийн 713.1 тэрбум төгрөгийн хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх; - 39 байгууллагын 77 нэрийн 2.2 тэрбум төгрөгийн балансын үнэ, 76.0 сая төгрөгийн улдэх өртөг бүхий хөдлөх хөрөнгийг нийт 179.0 сая төгрөгөөс эхлэн дуудаж, нээлтгэй дуудлагын худалдаагаар худалдаах; - 155 байгууллагын 2645 нэрийн 629.0 тэрбум төгрөгийн хөрөнгийг бүртгэх; - 45 байгууллагад 161 нэрийн 5.8 тэрбум төгрөгийн хөрөнгийг шинээр олж авах; - 5 байгууллагын 33486 нэрийн тэг улдэгдэлтэй хөрөнгийн бодит үнэ

						<p>цэнийг 1.2 тэрбум төгрөгөөр шинэчлэн тогтоосон зэрэг болно.</p> <p>Гарсан шийдвэрийг холбогдох байгууллагад хүргүүлэх, хэрэгжилт, тогтоолын биелэлтийг хангах ажлыг зохион байгуулж ажиллав.</p> <p>Нийт 713.0 тэрбум төгрөгийн илүүдэлтэй хөрөнгийг балансаас балансад шилжүүлснээр шинээр хөрөнгө худалдан авах зардлыг хэмнэж, энэ хэмжээгээр төсвийн зардал буурсан гэж дүгнэж байна.</p> <p><u>Өөрийн үнэлгээ:</u> “Үр дунтэй” – 100 %</p> <p><u>Тэмдэглэл:</u> Зорилт, арга хэмжээ нь шалгуур үзүүлэлт, зорилтот түвшинд хүрсэн. Удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээ авч, үр дүн гарсан.</p>
	7.Суудлын автомашины ашиглалтын талаар авах зарим арга хэмжээний тухай ЗГ-ын 2015 оны 184 дүгээр тогтоолыг хэрэгжүүлж, төрийн байгууллагуу-дын дотоод албан хэрэгцээнд ашиглах автомашины тоо, төрөл, нормативыг тогтоох, хяналт тавих замаар төсвийн зардлыг бууруулах арга хэмжээ авах	2016-2020	ТӨБЗГ	-	Зардал хэмнэгдэх	<p>ТӨБХ</p> <p>Энэ тогтоолын хэрэгжилтийн асуудлаар Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2020 оны 5 дугаар сарын 07-ны өдрийн А-1/841, А-1/842 дугаартай албан бичгээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт болон Төр, засгийн автобаазад тус тус хандан санал авсан.</p> <p>Засгийн газрын 2015 оны 184 дүгээр тогтоолд нэмэлт өөрчлөлт оруулах асуудлыг ЗГХЭГ-аас өгсөн чиглэлийн дагуу Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас судлан 2020 оны 9 дүгээр сард Засгийн газрын хуралд оруулан хэлэлцүүлэхээр ажиллаж байна.</p> <p><u>Өөрийн үнэлгээ:</u> “Эрчимжүүлэх шаардлагатай” – 40%</p> <p><u>Тэмдэглэл:</u> Зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг зорилтот түвшинд хүргэхэд чиглэсэн асуудлаар удирдлага, зохион байгуулалт болон холбогдох байгууллагын уялдаа холбоог сайжруулах арга хэмжээ авсан, цаашид үйл ажиллагааг эрчимжүүлэх шаардлагатай. Судалгаа, тооцоог шинчилж, үр дүнг тооцон дүгнэлт хийж, холбогдох байгууллагаар тодорхой шийдвэр гаргуулах, нормативыг тогтоох асуудлыг шийдвэрлүүлэх шаардлагатай гэж дүгнэв.</p>
	8.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийн мэдээллийн системийг боловсронгуй болгох	2016-2020	ТӨБЗГ	-	Мэдээллийн систем шинэчлэгдэн боловсронгуй болох, ашиглалтад оруулах	<p>ТӨБХ</p> <p>“Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-ийг боловсронгуй болгох ажилд шаардлагатай хөрөнгө төсөв батлагдахгүй, шийдвэрлэгдэхгүй байгаагаас бүхэлд нь сайжруулалт хийгдэх боломжгүй байгаа бөгөөд хуучин системийг ашиглаж, төрийн өмчийн бүртгэл, мэдээллийг нэгтгэж байна.</p>

					<p>Автомашины нээлттэй дуудлагын худалдааг цахим хэлбэрээр зохион байгуулах боломжийг бүрдүүлж, цахим программын хөгжүүлэлтийг хийсэн. Дуудлага худалдааг цахим хэлбэрээр зохион байгуулах хууль эрх зүйн орчин бүрдээгүйгээс дуудлага худалдааг цахим хэлбэрээр зохион байгуулахад ашиглах программ хангамжийг хэрэглээнд нэвтрүүлэх ажил хүлээгдэж байна.</p> <p>Түүнчлэн, төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээг дүгнэх, нэгтгэл тайланг цахимжуулах ажлыг хийж, цахим программ хангамжийг боловсруулж, хэрэглээнд нэвтрүүлэн ашиглаж байна.</p> <p>Тайлант хугацаанд, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-ийн хэвийн үйл ажиллагааг хангах болон хэрэглэгчдэд зөвлөгөө өгөх ажлыг тогтмол хийж ажилласан.</p> <p>Өөрийн үнэлгээ: “Эрчимжүүлэх шаардлагатай” – 40%</p> <p>Тэмдэглэл: Зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг зорилтот түвшинд хүргэх талаар удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээ авч, үйл ажиллагааг эрчимжүүлэх шаардлагатай. 2021 оны улсын төсөвт хөрөнгийн эх үүсвэрийг тусган шийдвэрлүүлэх тодорхой алхамыг хийх шаардлагатай гэж дүгнэв.</p> <p>“Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-ийн хөгжүүлэлтийн төлөвлөгөө, ажлын даалгавар, зардлын тооцоо судалгааг хийсний үндсэн дээр системийг шинэчлэн боловсронгуй болгох асуудлаар төсөл боловсруулж, санхүүжилтийг шийдвэрлүүлэх, шаардлагатай хөрөнгийг төсөвт тусгтуулахаар Сангийн яаманд хургуулж байсан.</p>
5.2.2. Төсөл, тендерийн шалгаруулалт ыг олон нийтэд ил тод болгож “Шилэн тендер шалгаруулалт” бодлого хэрэгжүүлнэ.	1.Худалдан авах ажиллагаанд олон улсын шилдэг арга туршилагыг нэвтрүүлэн, худалдан авах ажиллагааны хууль тогтоомжийг боловсронгуй болгож, цахим худалдан авах ажиллагааны нэгдсэн систем, дэд системүүдийг ўе шаттайгаар хэрэгжүүлэх замаар улсын хэмжээнд ашиглалтад бүрэн	2016-2020	ТӨБЗГ	-	<p>Төсвийн хөрөнгө оруулалт, төлөвлөлтийг худалдан авах ажиллагаатай уялдуулдаг болох, цутглуулсан өгөгдөл тулгуурлан</p> <p>ЗУА</p> <p>Монгол Улсын Засгийн газрын 2019 оны “Агентлаг байгуулах тухай” 438 дугаар тогтооюур Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын чиг үүрэг өөрчлөгджэй, Төрийн худалдан авах ажиллагааны чиг үүргийг хариуцсан бие даасан агентлаг шинээр байгуулагдсан.</p> <p>Өөрийн үнэлгээ: “Үнэлэх боломжгүй”</p> <p>Тэмдэглэл: 2019 оны зорилтот түвшингийн хувьд зорилт, арга хэмжээ нь шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ хүрч, үр дүн гарсан тул 100 хувь буюу “Үр дүнтэй” үнэлгээтэй дүгнэгдсэн. 2019 оны жилийн эцсийн дунгэрээр төрийн худалдан авах ажиллагааны цахим системийн үзүүлэлт 2018 оны мөн ўеэс дунджаар 20 хувиар ессөн үр дүн гарсан.</p>

	оруулах			шийдвэр гаргах боломжийг бурдуулэх	2020 оны зорилтот түвшингийн хэрэгжилт ТӨБЗГ-т хамаарахгүй болсон тул гүйцэтгэлийг үнэлэх боломжгүй.
	2.Төрийн өмчит хуулийн этгээдийн байнгын хэрэгцээтэй бараа, ажил, үйлчилгээний худалдан авалтыг ерөнхий гэрээ байгуулах замаар хэрэгжүүлэх хууль, эрх зүйн орчныг бүрдүүлж, хэрэгжилтийг хангах, мэдээллийн сан бурдуулж, баяжуулах	2016-2020	ТӨБЗГ	Ерөнхий гэрээний худалдан авалтыг цахим хэлбэрт шилжүүлж, e-shopping mall системийг ашиглалтад бүрэн оруулах, Улсын төсвийн эх үүсвэр: 10.0 сая төгрөг	<p>ЗУА</p> <p>Монгол Улсын Засгийн газрын 2019 оны “Агентлаг байгуулах тухай” 438 дугаар тогтоолоор Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын чиг үүрэг өөрчлөгджэй, Төрийн худалдан авах ажиллагааны чиг үүргийг хариуцсан бие даасан агентлаг шинээр байгуулагдсан.</p> <p><u>Төрийн үнэлгээ: “Үнэлэх боломжгүй”</u></p> <p>Тэмдэглэл: 2019 оны зорилтот түвшингийн хувьд зорилт, арга хэмжээ нь шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ хүрч, үр дүн гарсан тул 100 хувь буюу “Үр дүнтэй” үнэлгээтэй дүгнэгдсэн. 2019 оны жилийн эцсийн дүнгээр барааны каталогийн системийн баазыг бүрэн ашиглаж байгаа, каталогид бүртгэлтэй барааны тоо хэмжээ өмнөх оны мөн үеэс 13.5 хувиар нэмэгдсэн үр дүн гарсан.</p> <p>2020 оны зорилтот түвшингийн хэрэгжилт ТӨБЗГ-т хамаарахгүй болсон тул гүйцэтгэлийг үнэлэх боломжгүй.</p>

ХЭРЭГЖИЛТИЙН ДҮН

Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг уг хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө (ЗГУАХХАХТ)-нд тусгагдсан арга хэмжээ (заалт) бүрийн хэрэгжилт, үр дүнгээр тайлагнав. Нийт 4 бүлэг бодлогын хүрээний 7 тэргүүлэх зорилтод хамаарах 22 арга хэмжээг ТӨБЗГ-т хяналтад авч, хэрэгжилтийг тайлагнааж ирсэн. Эдгээр 22 арга хэмжээнээс 9 арга хэмжээг нь бусад байгууллагатай хамтран, 13 арга хэмжээг дэнгаар хариуцан хэрэгжүүлж байсан. Засгийн газрын 2018 оны 323, 438, 2020 оны 47 дугаар тогтоол гарсантай холбоотойгоор бусад байгууллагатай хамтран хэрэгжүүлэх 3, дангаар хариуцан хэрэгжүүлэх 2, нийт 5 арга хэмжээний 2020 оны зорилтот түвшингийн гүйцэтгэл ТӨБЗГ-т хамаarahгүй болсон буюу үнэлэх боломжгүй байна.

Үнэлгээний дунгийн товч танилцуулга (2020 оны эхний хагас жилийн дунгээр):


ЗГУАХХАХТ-нд тусгагдсан арга хэмжээ (заалт)-ний тоо – 22; Үнээс:

- “Үр дүнтэй” буюу 100 % - 5 арга хэмжээ;
- “Тодорхой үр дүнд хүрсэн” буюу 70 % - 4 арга хэмжээ;
- “Эрчимжүүлэх шаардлагатай” буюу 40 % - 3 арга хэмжээ;
- “Үр дүнгүй” буюу 0 % - 0;
- “Үнэлэх боломжгүй” – 10 арга хэмжээ, үүнээс 5 нь дээр дурдсан тогтоолоор ТӨБЗГ-т бүрэн хамаarahгүй болсон.

ЗГУАХХАХТ-ний тухайн жилийн зорилтот түвшингийн хэрэгжилтийн дундаж үнэлгээ (хувь) – 75.0 %.

ТАНИЛЦСАН:

ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЛЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ДАРГА



З.МЭНДСАЙХАН

ХЯНАСАН:

ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН АЛБАНЫ
ДАРГА

Л.САРНАЙ

ТАЙЛАНГ НЭГТГЭН БОЛОВСРУУЛСАН:

ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН АЛБАНЫ
ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН БИЕЛЭЛТ ХАРИУЦСАН
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Х.ЭНХЧИМЭГ